

МОНГОЛЬСКАЯ  
АКАДЕМИЯ НАУК  
Институт истории и  
этнологии

МЕЖДУНАРОДНАЯ  
АССОЦИАЦИЯ  
МОНГОЛОВЕДОВ

РОССИЙСКАЯ  
АКАДЕМИЯ НАУК  
Институт восточных  
рукописей



# КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: КОЛЛЕКЦИИ РУКОПИСЕЙ И АРХИВНЫХ ДОКУМЕНТОВ

## IV

**Международная конференция  
при поддержке Президента Монголии**



18-19 апреля, 2019. Улан-Батор

Сборник докладов

Санкт-Петербург — Улан-Батор  
2021

ННА 63.4  
ДAA 930.1  
М-694

|                                |                                                     |
|--------------------------------|-----------------------------------------------------|
| <b>Ответственный редактор:</b> | Академик С.Чулуун                                   |
| <b>Научные редакторы:</b>      | доктор филол. наук И.В.Кульганек<br>Ph.D Н.Хишигт   |
| <b>Редакторы, составители:</b> | Ph.D Б.Нацагдорж<br>канд. филол. наук. Н.С.Яхонтова |

**Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов.** Сборник докладов IV международной научной конференции. 18—19 апреля 2019 г. Улан-Батор. Россия. СПб.—УБ. 2021 г. —276 с.,

Сборник представляет собой собрание докладов IV международной научной конференции “Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов”, организованной Институтом истории и археологии МАН, Ассоциацией международных монголоведов и Институтом восточных рукописей РАН в г. Улан-Батор, 18—19 апреля 2019 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов. В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-9919-9646-7-2  
DOI 10.25882/z7ch-tr43

© Институт истории и этнологии МАН, 2021 г.  
© Институт восточных рукописей РАН, 2021 г.  
© Международная ассоциация монголоведов, 2021 г.

МОНГОЛ УЛСЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
АКАДЕМИ  
Түүх, угсаатны зүйн  
хүрээлэн



ОЛОН УЛСЫН  
МОНГОЛ СУДЛАЛЫН  
ХОЛБОО



ОРОСЫН ШИНЖЛЭХ  
УХААНЫ АКАДЕМИ  
Дорно дахины гар  
бичмэлийн хүрээлэн



# МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

## IV

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор  
зохион байгуулсан



Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2019 оны 4 сарын 18-19  
Монгол улсын Улаанбаатар хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург - Улаанбаатар  
2021

ННА 63.4  
ДАА 930.1  
М-694

**Хариуцлагатай редактор:** Академич С.Чулуун

**Эрдэм шинжилгээний редактор:**

Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек

Түүхийн ухааны доктор (Ph.D) Н.Хишигт

**Редактор, эмхэтгэгчид:**

Түүхийн ухааны доктор (Ph.D) Б.Нацагдорж

Хэлшинжлэлийн дэд эрдэмтэн Н.С.Яхонтова

**Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга**

- IV. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Монгол улс, Улаанбаатар хот. 2019 оны 4 дүгээр сарын 18-19. Санкт-Петербург-Улаанбаатар., 2019 г. 276 тал.

Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн болон Олон Улсын Монгол судлалын холбооноос 2019 оны 4 дүгээр сарын 18-19-нд Монгол улсын Улаанбаатар хотноо “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 4 дэх удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

ОХУ, Монгол улсын гар бичмэлийн сан хөмрөг, архивуудад хадгалагдаж байгаа монгол угсаатан ард түмнүүдийн түүх, хэл, соёлын арвин баялаг эх сурвалж нь тус хурлын эх суурь болсон юм. Эмхэтгэлд монгол судлалын түүх, дэлхийн ба Монгол, Оросын шинжлэх ухааны байдал, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, Монголын уламжлалт болон орчин үеийн нийгмийн асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүд багтсан болно.

ISBN 978-9919-9646-7-2

DOI 10.25882/z7ch-tr43

© Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2021

© ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2021.

© Олон улсын Монгол судлалын холбоо, 2021.

MONGOLIAN  
ACADEMY OF  
SCIENCES  
Institute of History  
and Ethnology



INTERNATIONAL  
ASSOCIATION FOR  
MONGOL STUDIES



RUSSIAN ACADEMY  
OF SCIENCES  
Institute of Oriental  
Manuscripts



# **CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS**

## **IV**

**International Conference  
Under the Patronage of the President of Mongolia**



April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia

Proceedings

St. Petersburg — Ulaanbaatar  
2021

ННА 63.4  
ДAA 930.1  
М-694

|                            |                                                                     |
|----------------------------|---------------------------------------------------------------------|
| <b>Managing Editor:</b>    | Academician S.Chuluun                                               |
| <b>Scientific Editors:</b> | Dr.Sc. (Philology) I.V.Kulganek<br>Ph.D (History) N.Khishigt        |
| <b>Editor, compiler:</b>   | Ph.D (History) B.Natsagdorj<br>Cand. Sc. (Philology) N.S.Yakhontova |

**Cultural heritage of the Mongols: manuscripts and archival collections.** Papers of the IV International Conference, April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia. St.Petersburg —Ulaanbaatar 2019, 276 pages.

This is a collection of papers, presented at the Fourth International Conference organized by the Institute of History and Archeology of the Mongolian Academy of Sciences, the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences and the International Association for Mongol Studies which was held in Ulaanbaatar on April 18-19, 2019.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples. The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN 978-9919-9646-7-2  
DOI 10.25882/z7ch-tr43

© Institute of History and Ethnology, MAS 2021  
© Institute of Oriental Manuscripts, RAS 2021  
© International Association for Mongol Studies, 2021

## ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ / CONTENT

|                                                                                                                  |     |
|------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| Өмнөтгөл (С.Чулуун) .....                                                                                        | 9   |
| <i>Г.Ариунтуяа</i>                                                                                               |     |
| Монгол Улсын Үндэсний Төв Архив дахь Ж.Цэвээний<br>хувийн хөмрөг .....                                           | 11  |
| <i>Д.Баярсайхан</i>                                                                                              |     |
| Монголчуудын тухай XIII-XIV зууны Армян сурвалжийн тойм .....                                                    | 23  |
| <i>Ts.P.Vanchikova</i>                                                                                           |     |
| Folklore Heritage of the Buryats in the Funds of the COMX and<br>Problems of its Research and Conservation ..... | 35  |
| <i>Ж.Гэрэлбадрах</i>                                                                                             |     |
| Монгол Улсын Газар зохион байгуулалт, Геодези, Зурагзүйн<br>газрын архивт буй нутгийн зургийн цуглуулга .....    | 43  |
| <i>Л.С.Дампилова</i>                                                                                             |     |
| Шаманские материалы в фонде Т.К.Алексеевой<br>в ЦВРК ИМБТ СО РАН .....                                           | 57  |
| <i>Ж.Долгорсүрэн</i>                                                                                             |     |
| Эрдэмтэн, зохиолч, найруулагч, орчуулагч Э.Оюун:<br>хэвлэгдээгүй гар бичмэл, намтрын баримтууд .....             | 65  |
| <i>Г.А.Дыргеева</i>                                                                                              |     |
| Традиционная письменная культура Бурят:<br>социоллингвистический аспект .....                                    | 73  |
| <i>Г.А.Гребенищикова</i>                                                                                         |     |
| Монголия в планах Военного и Морского ведомств России<br>в 1903-1913 годах .....                                 | 84  |
| <i>В.Ю.Жуков, И.В.Кульганек</i>                                                                                  |     |
| «История монголов» О.М.Ковалевского: первое прочтение .....                                                      | 98  |
| <i>И.М.Захарова, М.В.Мандрик</i>                                                                                 |     |
| К вопросу о деятельности Советника при Монгольском<br>правительстве П.А.Витте .....                              | 107 |
| <i>С.Мөнхсайхан</i>                                                                                              |     |
| Уламжлалт монгол хэл зүйн бичгүүдийн хэл шинжлэлийн<br>ач холбогдол хийгээд сурвалж бичгийн үнэ цэнэ .....       | 121 |
| <i>Б.Нацагдорж</i>                                                                                               |     |
| Тод үсгийн нэгэн захидлаас <i>Ойрад</i> хэмээх нэрийн тухай<br>тодруулах нь .....                                | 136 |

*Д.А.Носов*

Россыпи документов В.А.Казакевича: отчеты о поездках  
по Монголии 1923—1925 гг. .... 149

*К.В.Орлова*

Документальное наследие калмыков: письма калмыцких ханов ..... 160

*Р.Ю.Почекаев*

Суд и процесс в монгольских «Хождениях в ад» ..... 167

*Г.Сэр-Од*

Монгол Улсын Үндэсний төв архивын сан хөмрөг дэх  
Тамга, захирлага, тэмдгийн цуглуулга хөмрөг ..... 176

*М.В.Федорова*

Монгольские фотоколлекции конца XIX — начала XX вв.  
в собрании Российского этнографического музея, как источник  
для изучения традиционной культуры монголов ..... 186

*Ц.Цэрэндорж*

XV-XVIII зууны Солонгос сурвалж дахь Монголын түүхэнд  
холбогдох мэдээ баримтаас ..... 204

*Д.Энхцэцэг*

Монгол – Мингийн харилцаа: захидал бичгийн тухай ..... 219

*Ц.Энхчимэг*

“Төмөрийн цаазын бичиг”: Монголын эзэнт гүрний түүхийн  
чухал сурвалж болох нь ..... 240

*Н.С.Яхонтова*

Аспиранты из Монголии в Академии наук ..... 250

Сведения об авторах ..... 268

Зохиогчдын танилцуулга ..... 272



Б.Нацагдорж

## ТОД ҮСГИЙН НЭГЭН ЗАХИДЛААС ОЙРАД ХЭМЭЭХ НЭРИЙН ТУХАЙ ТОДРУУЛАХ НЬ

DOI 10.25882/vtfg-tr98

Оросын Шинжлэх ухааны академид ажиллаж байсан герман судлаач Петер Симон Паллас ойрад хэмээх нэрийг 1779 онд хэвлүүлсэн өөрийн бүтээлдээ анх тайлбарласнаас хойш энэхүү угсаатны нэрийн гарал үүслийн тухай өдий төдий өгүүлэл, зохиолууд гарч, олон янзын таамаглал дэвшүүлэгдсэн байна. Гэвч одоог хүртэл судлаачдын дунд нэгдсэн ойлголт тогтсон зүйлгүй байсаар буй. Иймд энэхүү бяцхан өгүүлэлд, БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр архивт хадгалагдаж байгаа, Хасагийн Аблай хаанаас Манж Чин улсаас Илийн газар суулгасан жанжинд илгээсэн тод үсгээр монгол хэлээр бичсэн нэгэн хувь захидлын агуулгыг шинжилж, ойрад хэмээгдсэн монголчуудын түүхэн хөгжлийн үйл явцыг харьцуулж үзсэний үндсэн дээр ойрад хэмээх нэрийн гарал болон хэрэглээний тухай өөрийн саналыг нэмэрлэхээр оролдлоо.

**Түлхүүр үгс:** Oyirad, Xasaq, холбоо, гурван жуз

B.Natsagdorj

## ON THE INTERPRETATION OF THE NAME OYIRAD: NEW EVIDENCE FROM THE RECENTLY DISCOVERED TODO-SCRIPT LETTER

Since German scientist Peter Simon Pallas, who worked at the Russian Academy of Sciences, gave the interpretation of the name Oyirad in his book published in 1779, there were many works and interpretations dedicated to this question. But there is still no consensus among them, one can say. Hereinafter, I have analyzed one newly discovered Oyirad letter written in Todo-script sent by Kazakh Ablai khan to the Qing officials stationed in Ili in 1767, now kept in the First Historical Archives of the PRC, with comparison of the history of Oyirad people and suggested my opinion on the name Oyirad.

**Keywords:** Oyirad, Xasaq, allies, three Zhuzes

## Ойрад нэрийн гарлын тухай судлаачдын дэвшүүлсэн таамаглал

Оросын Шинжлэх ухааны академид ажиллаж байсан герман судлаач Петер Симон Паллас 1779 онд хэвлүүлсэн *Sammlungen historischen Nachrichten über die mongolischen Völkerschaften* (Монгол ард түмнүүдийн тухай түүхийн мэдээний цуглуулга) хэмээх зохиолдоо анх *Dörben Oirat oder vier Verbündete* (Дөрвөн Ойрад буюу дөрвөн холбоотон) хэмээсэн үг гэж тайлбарласан юм<sup>1</sup>. Оросын Дорно дахин судлалыг үндэслэгчдийн нэг хар лам Иакинф буюу Н.Бичурин өөрийнхөө 1834 онд хэвлүүлсэн *Историческое обозрение Ойратов или Калмыков с XV столетия до настоящего времени* (XV зуунаас эдүгээ хүртэлх Ойрад буюу Халимагуудын түүхийн тойм) хэмээх зохиолдоо мөн энэхүү үзлийг зөвшөөрөн дагажээ. Тус номын 5-р талд: [*Ойрат* есть Монгольское слово; в переводе: союзный, ближний, союзник<sup>2</sup>] хэмээн бичсэнийг монголчилбоос, '*Ойрат гэдэг нь монгол үг бөгөөд орчуулбал: ойрын, холбооны, холбоотон хэмээсэн үг болой*' гэжээ. Түүний дараагаар Буриад монголын эрдэмтэн Банзарын Дорж 1849 онд *Ойрад* нэрийн тухай тусгай өөрийн саналыг дэвшүүлсэн '*Об ойратах и уйгурах*' хэмээх өгүүллээ нийтлүүлсэн бөгөөд өмнөх эрдэмтдийн дэвшүүлсэн ойр холбоотон гэсэн үгнээс үүсэлтэй хэмээх нь хэлзүйн төдийгүй түүхийн үндэслэлгүй, учир нь анх Чингис хааны цагт ойрад аймгийн нэр дурдагдахад тэд аймгийн холбоо бус харин тийм нэртэй нэг л аймаг байсан мөртөө Рашид-аддины тэмдэглэснээр ойд амьдардаг аймаг байсан тул энэхүү нэр нь *ой ард* хэмээх хоёр үг нийлж бүрдсэн ойн ард, ойн иргэн хэмээх утгатай гэж тайлбарласан юм<sup>3</sup>.

Үүний дараагаар Орос, Финландын нэрт эрдэмтэн Густав Рамстедт Ойрад нэрийн тухай өөрийн таамаглалаа дэвшүүлэв. Тэрбээр Банзаровын таамаглалын тухайд:

<sup>1</sup> Peter Simon Pallas. *Sammlungen historischer Nachrichten über die mongolischen Völkerschaften in einem ausführlichen Auzuge. Erster Teil.* Frankfurt und Leipzig, bei Johann Georg Fleischer. 1779. S. 8.

<sup>2</sup> Историческое обозрение ойратов или калмыков с XV столетия до настоящего времени. Сочинено монахом Иакинфом. Санкт-Петербург, Типография Медицинского департамента Министерства Внутренних дел. 1834. С.5.

<sup>3</sup> Доржи Банзаров. Об ойратах и уйгурах // Доржи Банзаров. Собрание сочинений. Москва, Издательство Академии Наук СССР. 1955. С.181-182.

*Бидний мэдэх монгол хэлний хэм хэмжээний үүднээс ой арад хэмээх нь багагүй хачирхалтай юм. Уг нь үүний оронд ойн-арад – “ойн ард түмэн” гэж байвал ойд амьдардаг ард түмнийг ойлгох бөгөөд зүгээр ой-арад эсхүл модон-күмүн гэвэл ой буюу модоор үйлдсэн хүмүүс гэсэн шүү утгатай болох юм<sup>4</sup>.*

хэмээн няцаагаад Алтай язгуурын хэлнүүдийн харилцан тохиролцох зүй тогтол зэрэгт үндэслэлсэн өөрийнхөө саналыг дэвшүүлсэн бөгөөд *oyirad* хэмээхийн язгуур нь *oyir* буюу *oyir* бөгөөд энэ нь түрэг хэлний *oguz* гэдэг лүгээ авиа зүйн үүднээс яг тохирох тул *ойрад* хэмээх нь монгол хэлний үүднээс *огуз* хэмээхийг нэрлэж дуудсан хэрэг болно гэсэн таамаглалыг дэвшүүлсэн юм. Үүний дараагаар халимагийн эрдэмтэн Н.Н.Убушаев *ойрад* хэмээх нэрийг фин хэлний *койра* буюу ‘нохой’ гэсэн үгнээс үүсэлтэй гэсэн таамаглал дэвшүүлжээ<sup>5</sup>. Хамгийн сүүлд 2010 онд Унгарын судлаач Бела Кемпф *ойрад* нэрийн тухай өөрийн саналыг дэвшүүлсэн бөгөөд эртний түрэг хэлний *ōu* буюу ‘адууны зүсний нэр бөгөөд гол төлөв хонгор зүснийг заадаг’ язгуур дээр -*gir* дагаврыг залгаж, дээр нь бүлгийн утга заадаг -(A)n дагавар залгаж, түүн дээр монгол хэлний олон тооны -*d* дагавар нэмэгдсэн үг гэж тайлбарлав<sup>6</sup>.

Ингээд одоо байгаа *ойрад* нэрийн тухай таамаглал тайлбаруудыг доор жагсааж үзүүлье.

- *oyira + d = oyirad* (*ойрд* буюу *ойрын холбоотон*)
- *oi + arad = oyirad* (*оин ард, ойн иргэд*)
- *oguz = oyiran + d = oyirad* (*огуз буюу огур нар*)
- *koira* (*фин*) + *d = (k) oirad* (*нохой буюу ноход*)
- *oy + gir + (A)n + d = oyirad* (*хонгор саарлууд*)

Үүнд, эдгээр таамаглалын дотроос хамгийн эхэнд буй тайлбарыг тухайн үеийн *ойрад* монголчууд өөрсдөө болон тэдний хөрш хасаг зэрэг нүүдэлчид хэрхэн үзэж ойлгож байсныг гэрчилсэн нэгэн сонирхолтой захидал бичиг олж үзсэнээ дор толилуулъя.

<sup>4</sup> Г.Рамстедт. Этимология имени ойрат // Сборник в честь семидесятилетия Григория Николаевича Потанина. Санкт-Петербург, Типография В.Ф.Киршбаума. 1909, С.550.

<sup>5</sup> Н.Н. Убушаев. Происхождение этнонима ойрат // Теегин герл. Свет в степи. Элиста, 1994.

<sup>6</sup> Bela Kempf. Ethnonyms and etymology–The case of Oyrat and beyond. // Ural-Altaisheer Jahrbücher. N. F. 24, (2010/2011) p. 192.

### Хасагийн Аблай хаанаас Илийн жанжинд илгээсэн захидал – 1767 он

Хасагийн Дунд жузын Аблай хаан 1767 онд өөрийн ач дүү Девлет Керей тэргүүтэй элч нарыг Манж Чин улсад томилж, Кокандын хаант улс лугаа хийж буй дайндаа цэрэг болон их буу гуйжээ. Чин улсын Тэнгэрийн тэтгэсэн хаанд өргөсөн 2 айлтгал болон Илийн жанжин Минрүйд илгээсэн 1 бичгийн манж орчуулга Чин улсын Цэргийн тухайн газрын манж дансны хуулганд орсон нь, судлаач эрдэмтдийн анхааралд өртөж, судалгааны эргэлтэнд орсон зүйл болно<sup>7</sup>. Харин эдгээр бичгийн тод үсгээр монгол хэлээр бичигдсэн уг эх нь үлдэж, хоцорсон эсэх нь мэдэгдэхгүй байсан юм.

Сүүлийн үед Казахстаны судлаачид БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр архивтай хамтран Казахстаны түүхэнд холбогдох архивын материалыг цуглуулан эмхэтгэж, хэвлүүлэх ажлыг идэвхитэй хийж гүйцэтгэж байна. Эдгээр судлаачдын нэг Бахыт Еженхан-үлы бээр дээр дурдсан бичгүүдийн нэг болох Аблай хаанаас Илийн жанжин Минрүйд өгсөн тод үсгийн бичгийг 2013 онд Хасаг-Чингийн харилцааны тухай илтгэлдээ анх гэрэл зурагчлан нийтлүүлжээ. Тэгэхдээ харин архивын эх сурвалжаа заасангүй<sup>8</sup>. Энэхүү бичиг нь, Хятадын Түүхийн Нэгдүгээр архивын Цэргийн тухайн газрын дансанд (*junjichu manwen loufu zouzhe*) 03-0182-2230-045 дугаартай хадгалагдаж буй бөгөөд энэ бичгийг архивт өөрөө үзэж, хадгалагдаж буй нэгжийн дугаар сэлтийг найрсгаар хуваалцсан номын садан Японы Тохокү Гакүин их сургуулийн багш Онума Такахиро сан-д энэ ташрамд талархлаа илэрхийлсүгэй.

Бахыт Еженхан-үлы-гийн илтгэлд хавсаргасан гэрэл зургийн чанар баахан муу боловч уг үсэг тодорхой танигдаж байх тул уг бичгийн эрдэм шинжилгээний галигийг үйлдсэнээ доор танилцуулъя.

1. ʘ abulai xān iliyin jangjingyuud ming
2. gūn-dū ilgebe yerü mani xasaq yurban
3. oyirod nigeni ula zūs nigeni orto

<sup>7</sup> Noda Jin, Onuma Takahiro. A Collection of the Kazakh Documents addressed to the Qing Dynasty. Department of Islamic Area Studies, Center for Evolving Humanities, Graduate School of Humanities and Sociology, The University of Tokyo. 2010, pp. 119-120.

<sup>8</sup> Еженхан Б. XVIII ғасырдың екінші жартысында шығыстағы қазақтардың атажұртына оралу тарихына қатысты тың дереккөздері // Материалы международной научно-практической конференции “История Казахстана: Инновационные концепции и периодизация как приоритет научного познания”. г. Алматы, 18 апреля 2013 г. Алматы, “Елтаным” баспасы. 2013, с. 144-148.

4. züs nigeni kiši züs mani ula züzüügi
5. burud erdeni xoyuula niyiled dobtol
6. –ji bida urzunan mordoji irēd dob
7. –tolji ababida burduugi tegēd el
8. keji xayidigiyini ababida buxār samar
9. –xan bolōd tere ergin ki uuγur
10. keletü zub cuyāran manlai el erdeni
11. gēči nige kümün manai dān oyironi bayiqsan
12. manai ulašiyigi amuruulxu biši bida
13. dayilixai odbo bida mantai yarči dayilal
14. daxu biši bāšingdān orōd kebtenei
15. töüni bāšinggiyini ebdekü yeke sumutai
16. zamarad buu ügei töüni učiriyini dēre
17. ezen boqdo xān-du ayiladxād ceriq
18. γuunayibida urzunun morduqsan ceriq
19. dērēse ilgebida coγuun köbögōse ene
20. elčiyigi ulāγār seriün γazar šuluun
21. ötörken kürgeqtün jangjing-du nige
22. üldü bülüüd öqböbi:: : ::
23. daülad kerē gün xara toxoi dār kā
24. ormōn kā xoton kā tas tömür kā muxulai
25. kā satān kā barang ötön bazar badarangyui
26. köböс item emegen

(Аблай хааны араб үсэгтэй тамга)

### Хөрвүүлэг ба тайлбар

Аблай хаан Илийн жанжингууд Мин гүнд илгээв. Ер манай Хасаг гурван ойрад. (онцлов - Б.Н.) Нэг нь Ула зүс [=Үлы жуз], нэг нь Орто зүс [=Орта жүз], нэг нь Киши зүс [=Киши жуз]. Манай Ула зүс [=Үлы жуз]-ийг Бурууд, Эрдэнэ хоёул нийлээд довтолж. Бид уржнан мордож ирээд довтолж авав бид буруудыг. Тэгээд эл хийж, хайдагийг нь авав бид. Бухар, Самарканд болоод тэр эргийнх уйгур хэлт зөв цугаар ман лугаа эл. Эрдэнэ гээч нэг хүн манай дай[са]н. Ойр нь байсан манай улсыг амруулах биш. Бид дайлахаа одов бид. Мантай гарч дайлалдах биш, байшиндаа ороод хэвтэнэ. Түүний байшинг нь эвдэх их сумтай замарад буу үгүй. Түүний учрыг нь дээр Эзэн богд хаанд айлтгаад цэрэг гуйна бид. Уржнан мордсон цэрэг дээрээс илгээв бид. Цогуун [=Чүйн] хөвөөгөөс энэ элчийг улаагаар Сэрүүн газар шулуун үтэрхэн хүргэгтүн. Жанжинд нэг үлд бүлүүд өгөв би. Девлет Керей гүн, Хар

тохой, Даар хиа, Ормоон хиа, Хотон хиа, Тас төмөр хиа, Мухулай хиа, Баран, Өтөн, Базар, Бадрангуй, Көбөс, Итэм, Эмгэн.

(Аблай хааны араб үсэгтэй тамга)

1.1 *abulai xān*: (Аблай хаан) Хасагийн Дунд жузын хаан (1771-1781). Чингис хааны ууган хүү Жүчийн удам. 1771 онд Хасагийн Дунд жузын хаан Абулмамбет нас барсны дараа Дунд жузын хаан өргөмжлөгдсөн боловч бүр 1750-иад оны дунд үеэс ойрад, манж лугаа харилцаж эхлэх үеэс хаан цолтой тэмдэглэгдэж байсан юм.

1.1-2 *iliyin jangjinguud ming gūn*: (Илийн жанжингууд Мин гүн) Илим дарангуй цэрэг захиран сууж байсан жанжин 誠嘉毅勇公 (*chéngjiā yǒng gong*) гүн Минрүй 明瑞. Манжийн хөвөөт шар хошууны хүн, фүча овогтой. 1756 оноос эхлэн Илийн газар цэрэгт зүтгэж, 1762 онд Илийн зэрэг газрын жанжин тавигдав<sup>9</sup>. Хасагийн элч нарыг ирэхээс өмнө 1767 онд халагдаж буцсаныг хасагийн Аблай хаан мэдээгүй учир энэхүү бичгийг Минрүй-д хаяглан илгээсэн ажээ.

1.3-4 *ula züs; orto züs; kiši züs*: (Үлы жүз, Орта жүз, Киши жүз) Хасаг хэлний Үлы жүз, Орта жүз, Киши жүз буюу Их зуу, Дунд зуу, Бага зуу гэсэн үгсийг галиглан бичсэн хэлбэр.

1.5 *burud*: (Бурууд) Тод үсгийн сурвалжид гардаг *burud* буюу бурууд нь Тэнгэр уулаар нутаглах түрэг хэлтэн, ислам шашинт нүүдэлчин кыргыз нарыг хэлдэг. Бурууд хэмээх нэр нь тэдгээр кыргыз нарыг исламын шашин буюу буруу номтон хэмээн бурханы шашинтай ойрад нараас дуудсан нэр болно.

1.5 *erdeni*: (Эрдэнэ) Түрэг хэлтэн нүүдэлчин үзбек нарын байгуулсан Дундад Азид оршин байсан Кокандын хаант улсын эзэн, бий цолтой минг овгийн хүн. Түүний эх нь, ойрад хатан байсан тул Зүүнгарын улс мөхсөний дараа өдий төдий ойрад хүмүүс түүнийг түшээр ирж, цэргийн алба хаан суух болжээ.

1.6 *urzunai*: (уржнан) Тус бичгийг илгээсэн 1767 оноос урагш тоолох тул 1765 оныг хэлжээ.

1.7-8 *el keji*: (эл хийж) Энд гарч буй *el* хэмээх үг нь найрамдал гэсэн утгатай үг бөгөөд 17-18-р зуунд холбогдох тод үсгийн дурсгалуудад тодорхой гардаг. Оросын II Екатерина хатан хаан 1769 онд Османы Түрэгтэй дайн зарласан тухай халимагуудад мэдэгдсэн зарлигийн

<sup>9</sup> Arthur W. Hummel. Eminent Chinese of the Ch'ing period (1644-1912). Volume 1, A-O. Library of Congress. 1944, p. 578.

орчуулгад оросын *мир* гэдгийг *el* гэж орчуулсан байдаг<sup>10</sup>. Мөн тэр үеийн монгол үсгийн дурсгалуудад ч найрамдал гэсэн утгатай тохиолддог билээ<sup>11</sup>.

1.8 *хайдигийни абабид*: (хайдгийг нь авав бид) Энд гарч буй *хайдиг* буюу *хайдау* хэмээх үг нь, барьцааны хүн данж авсан гэсэн утгатай гарч байна. Тод үсгийн сурвалж бичгүүдэд яг ийм утгаар хэрэглэгдсэн жишээ буй. 1743 онд Зүүнгарын Шар Манж ноёноос Оренбургийн комиссийн дарга И.И.Неплюевт хасагийн Дунд ба Бага жуз Зүүнгарт харьяалагдах тухай бичиж илгээсэн захидалд [... *hasagiyn uqtu noyon tüükü xani ačini abul meted xan köböügēn xayidaq ilgeji: baruq čigi köböü-gēn хойитун selēn-diin ilgenei bi geji elčīn ilgeji:*] (Хасагийн угт ноён Тауке хааны ач нь Абулмамбет хаан хөвүүнээ хайдаг илгээж, Баруг ч хөвүүнээ хойтон сэлгээнд нь илгээнэ би гэж элчээ илгээж) хэмээснийг орос орчуулгад [... *и потому вышеписанного касачкого Тюме-хана внук Абулмамбет-хан дал в аманаты сына своего, а Барак обещал впредь онаго аманата переменить своим сыном и с тем прислал своего посланца.*] (Ийм учраас дээр өгүүлсэн хасагийн Тауке хааны ач Абулмамбет хаан өөрийн хүүгээ данж болгон өгч, Барак тэр данжийг дараа нь өөрийн хүүтээр солино хэмээн элчээ илгээсэн билээ) гэж гардгаас тодорхой мэдэгдэж байна<sup>12</sup>.

1.9-10 *иуур келетү* (уйгур хэлт) Энд гарч буй *иуур келетү* хэмээсэн үг нь, түрэг хэлтэн гэсэн утгатай юм. Учир нь, дархад монголчууд тува хэлтэй цаатан духа нарын хэлийг уйгар хэл гэдэг бол Түнхэний буриад нар мөн тува хэлний нэгэн салбар болох тофа хэлийг уйгар хэл гэж хэлдэг билээ. Халимаг хэлэнд харин *иуур* буюу *ууһр* хэмээх нь, харь

<sup>10</sup> ‘...По вероломству порты отоманской, нарушившей без всякой законной притчины **мир поныне продолжавшейся**, дав мы великая государыня наше императорское величество всевысочайшее повеление действовать нашим войскам против турок и татар в двух разных сторонах...’ [türügi odō kürtele bayıqsan **eliyin yosuyigi** tong uçır uçır ügeyigēr ebdeji: itegel ügei boluqsārni: bida yeke ezen imperātirica: bidani cerigi kinas yolican. yarab rümēn cob хойор general an čeb-tu axalaoulji: хойор анги yazarār yabuji: türügi bolōd: mangyadoudi dayilaxāran] // Письма наместника калмыцкого ханства Убаши (XVIII в). Издание текст, ведение, транслитерация, перевод со старокалмыцкого на современный калмыцкий язык, словарь Д.Б.Гедеевой. Элиста, “Джангар”. 2004. С.109, 121.

<sup>11</sup> Tsongol B.Natsagdorj. Three Mongolian letters of Oyirad Noblemen from 1641-1642. // Oyirad Studies 3. Budapest. 2018, pp. 87-105.

<sup>12</sup> 1743 г. февраля 1. – Письмо джунгарского нойона Сары-Манджи начальнику Оренбургской комиссии И.И. Неплюеву о подданстве казахов Среднего и Младшего жузов. // Русско-джунгарские отношения. (конец XVII-60-е гг. XVIII вв.) Документы и извлечения. Издательство “Азбука”. Барнаул, 2006. С.83-84; 284-285.



хүнийг заасан утга нь шилжиж орос хүнийг заадаг үг болж хувирчээ<sup>13</sup>.

1.16 *zamarad buu*: (замарад буу) Энд гарч буй *zamarad* хэмээх үг тухайн үеийн тод үсгийн дурсгалуудад тохиолдохгүй байна. Үүнийг хойно өгүүлэх Тэнгэрийн тэтгэсэн хаанд барьсан Аблай хааны бичгийн манж орчуулгад *amba roo* гэснээс үзвэл их бууг хэлж байгаа нь тодорхой байна. Хасаг хэлэнд их буу хэмээсэн утгатай *зеңбірек* хэмээсэн үг байдаг<sup>14</sup> бол хиргис хэлэнд их буу хэмээхийг *замбирек* хэмээдэг аж<sup>15</sup>. Эдгээр нь перс хэлнээс нэвтэрсэн тэмээнд ачин явдаг жижиг гунан бууг нэрийдсэн *zanbūrak* хэмээх үг<sup>16</sup> бөгөөд Дундад Азийн түрэг хэлнүүдэд харин их бууг нэрийдэх ерөнхий нэр болсон байна.

1.19 *soyiun köböğöse*: (Чүйн хөвөөнөөс) Кыргызстаны Алатоо уулнаас эх аван урсч өмнөд Казахстан хүрч ширгэдэг голыг хэлж байна. Аблай хааны Тэнгэрийн тэтгэсэнд өргөсөн бичгийн манж орчуулганд *coi sere ba* (Чүй хэмээх газар)-аас илгээв хэмээснээс тодорхой байна.

1.20 *seriün yazar*: (Сэрүүн газар) Энд хэлж буй Сэрүүн газар гэдэг нь Хэбэй мужийн хойд этгээдэд Монгол нутгийн зах Халуун голд Манжийн хаадын байгуулсан Халуунаас зайлах ордон буюу Манжийн хаадын зуслан байсан урамдлын ав хоморго үйлддэг газар орныг хэлж байна. Монгол, Хасаг, Бурууд зэрэг Төв Азийн улс түмний элч төлөөлөгчид Бээжин хотод хүрч Манжийн хаанд бараалхвал цэцэг өвчин зэрэг халуун дулаан орны өвчин тусч үрэгдэх нь элбэг байсан тул ийнхүү зун намрын халуун цагт тус газар Манжийн хааныг зусч байх үед ирж бараалхан ав хоморгод оролцох нь нэгэн зүйлийн түгээмэл ёс болсон байжээ.

Энэхүү бичгийн хамт Аблай хаанаас Тэнгэрийн тэтгэсэн хаанд илгээсэн бичгийн манж орчуулга хадгалагдаж ирснийг энд харьцуулан үзье.


<sup>13</sup> [ууһр – табу. уст. русский; ууһр хүн русский человек] Б.Д.Муниев. Калмыцко-русский словарь. Москва, Издательство “Русский язык”. 1977, С.540.

<sup>14</sup> [зеңбірек – артиллерия, орудие, пушка, пулемет] Калдыбай Бектаев. Казахско-русский словарь. Алматы, 1996. С.220.

<sup>15</sup> [замбирек - пушка] Киргизско-русский словарь. Составил профессор К.К.Юдахин. Фрунзе, 1985. С.288.

<sup>16</sup> <https://iranicaonline.org/articles/firearms-i-history> Encyclopedia Iranica Ираны нэвтэрхий толь вебсайт.






Дээд эзэн богд хаанд амгаланг эрмүй. Уржнан жилээс нааш цэрэглэж явсан учраа гаргаж бичиг айлтгав. Угаас манай хасаг гурван аймаг бөлгөө. (онцлов – зох.) Нэг нь болбоос Үлү юсү [=Үлы жуз], нэг нь болбоос Орто юсү [=Орта жуз], нэг нь болбоос Киши юс [=Киши жуз]. Бурууд, Эрдэнийн хоёр аймаг нийлж манай Үлү юсийг довтлов. Уржнан жил бид мөн цэрэг илгээж буруудыг довтлов. Хойно найрамдсугай хэмээн харилцан хүн явуулав. Бухар, Самарканд тойрон бүхий хотон хэл хэлэлцэх ард цөм найртай. Гагц Эрдэнэ манай зүг дайсан. Бид цөм Жанибек хааны гурван хүүгийн үрс. Үүний дотор хоёр хүүгийн үр Ташкент, Бишкек газарт суусан бөлгөө. Бишкек газарт бүхий надад дүү болох Искандер хэмээх хааныг өнгөрсөн жил Эрдэнэ алсан бөгөөд бас хоёр дүү, дөрвөн хүүг нь алж, эм хүүхдийг олзолж авав. Искандерийн давхар биетэй эмийн хэвлийг цавчиж хүүг алав. Нутгийг эзлэн авав. Тэдний явсан учир энэ. Жич урьд танд мөхөөгдсөн Хожижанг дагалдан явсан хэдэн ойрад босч Эрдэнийг дагалдан явмуй. Бас босч одсон цөөн бурууд нарыг хураав. Иймийн тул дайлаар одов. Харин биднээс урьдан гарч байлдсанд бид Базарчи баатар хэмээх сайн хүнийг эхлэн нэлээд хүнийг алав. Манд дарагдаж Бишкек хотонд орж гарахгүй болов. Үүнд Бишкек хотыг авсугай хэмээвээс их буу үгүй. Байлдсугай хэмээвээс тэд бас гарч ирэхгүй. ... буцсугай хэмээвээс манай ойр тойрон ... нутгийг амгалан байлгахгүй. Иймийн тул бид дээд их эзнээс хоёр түмэн цэрэг, их буу гуймуй.

Аблай хаан жич тайж нар ахалсан ард бүгдээр тамга дарж дуртайяа боол болсугай хэмээмүй. Олзын дээж тэрмэн дээл нэг, илд нэг, гутал нэг хос, хэдэн морь барив. Девлет Керей гүн, Хартохой, Даяр хиа, Орман хиа, Хотон хиа, Тастөмөр хиа, Мухулай хиа, Сантан хиа, Баран, Өтөн Базар, Бадрангуй, Күбүс, Итэн, Эмгэн. Чүй хэмээх газарт суусан цэргийн газраас дөрвөн сарын арванд мордуулав<sup>17</sup>.

Үүнд, Аблай хааны Илийн жанжин Минрүй гүнд илгээсэн бичигт гарсан [*yerü mani xasaq yurban oyirod nigeni ula züs nigeni orto züs nigeni kiši züs*] хэмээсэн үгийг манжаар орчуулахдаа [*daci meni hasak ilan aiman / bihe. emke oci ulu yusu. emke / oci orto yusu. emke oci kiši / yusu*] (Угаас манай Хасаг гурван аймаг бөлгөө. Нэг нь болбоос Үлы жуз, нэг нь болбоос Орта жуз, нэг нь болбоос Киши жуз)] гэсэн байна. Өөрөөр хэлбэл, тод үсгийн захидалд гарсан *oyirod* хэмээх үгийг манжаар *aiman* (аймаг) хэмээн орчуулсан байна. Харин тухайн үеийн орос хэлний бичиг баримтанд энэхүү жуз хэмээхийг *орда* (орд буюу нүүдэлчдийн улс иргэн) гэж орчуулж байсан юм.

<sup>17</sup> [dergi ejen enduringge han de elhe be / baimbi. cara aniya ci ebsi. coohalafi / yabuha turgun be tucibume bithe / wesimbuhe. daci meni hasak ilan aiman / bihe. emke oci ulu yusu. emke / oci orto yusu. emke oci kiši / yusu. burut. erdeni juwe aiman acafi / meni ulu yusu be tabcilaha. cara / aniya be inu cooha unggifi burut be / tabcilaha. amala hūwaliyaki seme ishunde / niyalma yabubuha. buhar. samarhan jai / šurdeme bisire hoise gisun gisurere / urse gemu hūwaliyasun. damu erdeni meni / baru dain. be gemu janabak han i ilan / jui i enen. erei dorgi juwe jui i enen / tasigan. bişiket bade tehe bihe. / bişiket bade bisire minde deo ojoro / isk'andir sere han be duleke aniya / erdeni waha bime. geli juwe deo / duin jui be wafi. juse sargan be / oljlame gaiha. isk'andir i jursu beye / sargan i hefeli be sacifi jui be / waha. nukte be ejeleme gaiha. ceni / yabuha turgun ere. jai neneme suwede / mukiye buhe hojijan be dahalame yabuha utu / ület ukafi erdeni be dahalame yabumbi. / geli ukafi genehe komso burut sebe / inu bargiyaha. uttu ofi be dailame / genehe. ese hono menci nendeme tucifi / afaha de be bazarci baturu sere / sain niyalma be turulame wafi kejine / niyalma be waha. mende gidabufi bişiket / hoton de dosifi tucirakū oho. ede / bişiket hoton be gaike seci amba / poo akū. afaki seci ce geli tucirakū / ... mariki seci meni hanci šurdeme / ... nukte be elhe bahaburakū. uttu / ofi. be / dergi amba ejen ci juwe tumen cooha. / amba poo be baimbi. abulai han / jai taijisa. ahūcilaha urse. uhei doron gidafi cihanggai gemu aha oki / sembi. olji i deji terme etuku emke / loho emke. gūlha emu juru utu / morin be / jafaha. dulet kere gung. haratohoi. dayar / hiya. orman hiya. hoton hiya. tastemur / hiya. muhūlai hiya. santan hiya. barang. / utun bazar. badaranggui. kubus. iten / emegen. coi sere bade tehe coohai baci duin biyai juwan de jurambuha.] // Қазақстан тарихы туралы қытай деректемлеры. III том. Цин патшалық дәуірінің мұрағат құжаттары. Алматы “Дайк пресс”, 2006. С.241-244.



Хасагийн хаант улс нь 17-р зууны эхэн үеэс эхлэн гурван жуз хэмээх хэсэгт хуваагдаж байсан бөгөөд 1718 онд бүх хасагийн Тауке хаан нас барсны дараа энэ гурван жуз нь тус бүр өөрийн хаан өргөмжилж, Хасагийн нэгдсэн хаант улс задарсан хэмээдэг<sup>18</sup>. Хасагийн Аблай хаан 1757 онд Амарсанаагийн асуудлаар ирсэн Чин улсын сайд Нусан нарт: “Манай хасагийн Орто-юс, Үлү-юс, Кэши-юс гурван аймагт цөм сурвалжлуулан байцаан хүн илгээж магадлуулав”<sup>19</sup> хэмээж байсан бол 1758 онд Тэнгэрийн тэтгэсэн хаанд бараалхаар ирсэн хасагийн элч Жолан: “Манай хасагт Үлү-юс, Орто-юс, Кичи-юс хэмээх гурван хасаг буй. Өөлд хэлээр Их зуу, Дунд зуу, Бага зуу хэмээмүй. Угаас цөм Хүнхээр улсаас ирсэн нь хэмээн сонсов”<sup>20</sup> хэмээн өгүүлж байснаас тодорхой мэдэгдэнэ. Өөрөөр хэлбэл Хасагийн хаант улс нь жуз хэмээх нэртэй 3 нэгжээс бүрдэж байсан гэсэн үг юм.

Гэтэл энэ гурван жуз гэдгийг Аблай хаанаас Чин улсын сайд нарт илгээсэн тод үсгийн захидалд *yurban oyirod* хэмээсэн нь, хасагууд өөрсдийгөө ойрад гэж хэлсэн үг биш болох нь тодорхой. Харин Хасагийн хаант улсыг бүрдүүлэх жуз гэдэг нэгжийг *oyirod* гэж хэлсэн

<sup>18</sup> Jin Noda. The Kazakh khanates between the Russian and Qing Empires. Brill. Leiden-Boston. 2016. pp. 3-4.

<sup>19</sup> [meni hasak i ortoyus. uluyus. kesiyus. ilan aiman de gemu fujurulame baicame niyalma unggifi yargiyalabuha.] // Qingdai xinjiang manwen dang'an huibian. Guangzhou, Guangxi shifan daxue chubanshe, 2012. Volume 25. p. 393.


<sup>20</sup> [meni hasak de uluyus, ortoyus, kiciyus sere ilan hasak bi. ület gisun de ike joo, dumda joo, бага joo sembi. daci gemu kungker gurun ci jihengge seme donjiha.] // Jin Noda. The Kazakh khanates between the Russian and Qing Empires. Brill. Leiden-Boston. 2016. pp. 168-169.

болох нь ил байна. 1755-1758 онд Чингийн цэрэгт эзлэгдсэн Зүүнгар улсын ард иргэд аллага хядлага, өвчин тахлаас зайлан тал бүр тархан сарниснаас нэлээд хүн Хасагт дагаар орж, Хасагийн Аблай хаан нарт үйлчилж хасаг нарын Манж Чин улстай харилцахад зуучийн үүрэг гүйцэтгэж, ойрадын хэл бичиг нь хоёр этгээдийн харилцах гүүр болж байсан юм<sup>21</sup>. Энэхүү бичгийг авчирсан Аблай хааны элч нарын нэрсийг үзэхүл тэргүүлсэн элчээс бусад нь ихэнх нь өөлд монголчууд байна. Тэгэхээр Аблай хааны дэргэд үйлчилж байсан ойрад нар *ойрад* хэмээх нэрийг аливаа нэгэн холбоог бүрдүүлэх нэгжийн нэр гэж ойлгож ухамсарлаж байсан нь энэхүү захидлаас мэдэгдэж байна. Паллас авгайн хамгийн анх *Ойрад* нэрийн тухай дурдсан санал нь, харин ойрадуудын өөрсдийнх нь үзэлт байсан ажээ.

### Дүгнэлт

1767 онд Аблай хаанаас Манж Чин улсад хандан цэрэг, зэвсгийн тусламж гуйсан элч мордуулахад тод үсгээр бичсэн захидал бичгийг өгч илгээв. Тэдний Илийн жанжинд өгсөн тод үсгийн захидал бичигт, ойрад нэрийн тухай ойрадуудын өөрсдийнх нь үзэл тусч үлдсэн байна. Ойрадууд өөрсдөө мөн тэднээс уламжлаад хасагууд *ойрад* хэмээх үгийг *oyir-a* гэдгээс үүссэн холбоотон гэсэн үг гэж ойлгож байсан ажээ. Мэдээж, XVIII зууны дунд үед ойрадууд өөрсдөө *ойрад* хэмээх үгийг холбоотон, холбоо хэмээн үзэж ойлгож байсан нь, ерөөс энэхүү нэр нь *ойр* буюу *холбоо* гэдэг үгээс анх үүссэнийг баталж чадахгүй. Гэвч анх ямар ч утгатай нэрнээс үүссэн бай, түүхэн хөгжлийнхөө явцад энэхүү үг нь ойрын, холбоотон гэсэн утгатай гэж ойлгогдох болж, Зүүнгарын улсын ойрад хүмүүс өөрсдөө ингэж ойлгож, тайлбарлаж байсан нь бидний хувьд чухал юм. Үүнд хэзээ ямагт *Дөрвөн ойрад* хэмээн хоршин хэрэглэж байсан нь зохих хэмжээнд нөлөөлсөн ч байж болно.

<sup>21</sup> Бенжамин Леви. Зүүнгар дахь Чингийн аян дайн ба сарнисан ойрадуудыг Илим нутаглуулсан нь. // Historia Mongolarum. Түүх (X). Улаанбаатар, 2011. 66-112-р тал.



Хасагийн Аблай хаанаас Манж Чин улсын Илим суусан  
жанжни Минрүй гүнд илгэсэн захидал 1767 он.

БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр архив. Цэргийн тухайн газрын данс. (junjichu manwen loufu zouzhe 03-0182-2230-045); Еженхан Б. XVIII гасырдың екінші жартысында шығыстағы казактардың атажуртына оралу тарихына катысты гың дереккөздері // Материалы международной научно-практической конференции “История Казахстана: Инновационные концепции и периодизация как приоритет научного познания”. г.Алматы, 18 апреля 2013 г. Алматы, “Елтаным” баспасы. 2013, С.148.